



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/499

Улаанбаатар хот

2018 онд ерөнхий гэрээ байгуулан
худалдан авах эмийн жагсаалтад
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтыг тус тус үндэслэн, “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 29 дүгээр тогтоолын 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны 2017 оны 22 дугаар тогтоолын 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газар Олон Улсын валютын сангийн хооронд 2017 оны 05 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”, Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй хэрэгжиж буй “Улсын эмнэлгүүдийн боломжит үнийн эмийн хүртээмжийг сайжруулах” техник туслалцааны төслийн хэрэгжилтийг тус тус хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Төрийн өмчийн эмнэлгүүдэд 2018 онд ерөнхий гэрээ байгуулан худалдан авах эмийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Хавсралтад заагдсан эмийн техникийн тодорхойлолтыг гарган Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/411 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081636

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 12 сарын 08-ны өдрийн
А/499 дугаар тушаалын хавсралт



**Төрийн өмчийн эмнэлгүүдэд 2018 онд ерөнхий
гэрээ байгуулан худалдах авах эмийн жагсаалт**

Д/Д	Эмийн олон улсын нэршил	Тун, хэмжээ	Эмийн хэлбэр	Савлалтын хэлбэр
1.	Амоксициллин+клавуланы хүчил	500мг+ 125мг	бүрхүүлтэй шахмал, капсул	№10-100 хүртэл ширхэгтэй
2.	Атракриум	25мг-2.5мл	тарилгын уусмал	туншил
3.	Бупивакайн гидрохлорид	5мг/мл - 4мл	тарилгын уусмал	туншил
4.	Виллебранд, гемофилийн эсрэг VIII факторын холимог фактор	500 ОУН	тарилгын уусмал	флакон
5.	Гемофилийн эсрэг VIII фактор	500 ОУН	тарилгын уусмал	флакон
6.	Гемофилийн эсрэг VIII фактор	250 ОУН	тарилгын уусмал	флакон
7.	Гемофилийн эсрэг IX фактор	500 ОУН	тарилгын уусмал	флакон
8.	Гемофилийн эсрэг IX фактор	250 ОУН	тарилгын уусмал	флакон
9.	Диклофенак түүний давсууд	100мг	шулуун гэдэсний лаа	№5-10 хүртэл ширхэгтэй
10.	Инсулин богино	100 ОУН/мл - 3мл	тарилгын уусмал	туншил
11.	Инсулин урт	100 ОУН/мл - 3мл	тарилгын уусмал	туншил
12.	Клопидогрел	75мг	бүрхүүлтэй шахмал	№10-100 хүртэл ширхэгтэй

<i>Д/Д</i>	<i>Эмийн олон улсын нэршил</i>	<i>Тун, хэмжээ</i>	<i>Эмийн хэлбэр</i>	<i>Савлалтын хэлбэр</i>
13.	Лизиноприл дигидрат	10мг	шахмал, бүрхүүлтэй шахмал	№10-100 хүртэл ширхэгтэй
14.	Лозартан түүний давсууд	50мг	бүрхүүлтэй шахмал, капсул	№10-100 хүртэл ширхэгтэй
15.	Пантопразол	20мг	бүрхүүлтэй шахмал, капсул	№10-100 хүртэл ширхэгтэй
16.	Севофлуран	250мл	ингаляцийн уусмал	флакон
17.	Спиронолактон	25мг	шахмал, бүрхүүлтэй шахмал, капсул	№10-100 хүртэл ширхэгтэй